



МОНГОЛ УЛС  
МОНГОЛБАНК

15160 Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Утас: 31-03-92 Факс: (976-11) 31-14-71  
<http://www.mongolbank.mn>

2018.07.04 № А-1/842  
тантай 2018.06.22-ны № 33 -1

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
О.БАТНАСАН ТАНАА

Таны 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн  
33 тоот албан бичгээр ирүүлсэн асуултын хариуг  
хавсралтаар хүргүүлж буйг хүлээн авна уу.  
Хавсралт 2 хуудастай.

Хүндэтгэсэн

МОНГОЛБАНКНЫ  
ЕРӨНХИЙЛӨГЧ



О.БАЯРТСАЙХАН

14 2776

A5-2018.doc

**Асуулт 1: Ам.долларын ханш огцом өсөхөд нөлөөлсөн гол шалтгаан юу вэ?**

Жил бүрийн 2 дугаар улиралд уул уурхай, барилга, хөдөө аж ахуйн салбар идэвхждэгтэй холбоотойгоор гадаад валютын эрэлт нэмэгддэг. Мөн эдийн засгийн өсөлт эрчимжиж байгаагаас үүдэн эхний 5 сарын байдлаар импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 45 хувиар өссөн. Үүний 8 хувийг хэрэглээний импорт, үлдсэн 37 хувийг аж үйлдвэр, уул уурхайн салбарын тоног төхөөрөмж, нефтийн бүтээгдэхүүн зэрэг ирээдүйд өсөлт бий болгох хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт бүрдүүлж байна. Импортын огцом өсөлтөөс шалтгаалан гадаад валютын өндөр эрэлт бий болсон нь ам.долларын ханшид нөлөөлөв.

**Асуулт 2: Ам.долларын ханш өссөнөөр улсын төсөвт нэмэгдэж ирэх ачааллын талаар?**

Ам.долларын ханшийн улсын төсөвт хэрхэн нөлөөлөх тухай албан ёсны тооцооллыг Сангийн яамнаас тодруулах нь зүйтэй гэж үзэж байна.

**Асуулт 3: Ам.долларын ханш иргэд, аж ахуйн нэгж байгууллагад нэмэгдэж ирэх ачааллын талаар?**

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш инфляцид хэрхэн нөлөөлдөг талаар Монголбанкнаас хийгдсэн судалгааны ажлуудын үр дүнгээс үзэхэд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш 1 нэгж хувиар сулрах нь инфляцийг жилийн дотор 0.32-0.45 нэгж хувиар өсгөх нөлөөтэй гэсэн үр дүн гарсан байдаг. Өөрөөр хэлбэл төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1 хувь буюу 24.6 төгрөгөөр сулрахад өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ дунджаар 0.32-0.45%-иар өсдөг байна.

**Асуулт 4: Ам.долларын ханшийн одоогийн байдлыг богино хугацаанд яаж зохицуулах гэж байна вэ?**

Монголбанк зах зээлд үүссэн валют ханшийн хэлбэлзлийг түр зуурын шинжтэй гэж үзэж байгаа бөгөөд уг хэлбэлзлийг бууруулах зорилгоор Монголбанкнаас 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдөр ээлжит бус гадаад валютын дуудлага худалдаагаар 88.7 сая ам.доллар, 6 дугаар сарын 26-ны өдрийн дуудлага худалдаагаар 38.3 сая ам.долларыг тус тус нийлүүлсэн. Улмаар төгрөгийн ханшийн хэлбэлзэл буурсан.

Дэлхийн зах зээл дэх эрдэс бүтээгдэхүүний үнэ өсч, гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр гадаад худалдааны ашиг 706.4 сая ам.долларт хүрсэн. Мөн Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлтүүд сайжирч, зээлжих зэрэглэл өссөн зэргээс шалтгаалан хөрөнгө оруулагчдын итгэл сэргэсэнээр 2018 оны эхний 5 сард гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.9 дахин өсч, 643.9 сая ам.долларт хүрсэн. Улмаар төлбөрийн тэнцэл 2018 оны эхний 5 сард 201.7 сая ам.долларын ашигтай гарсан. Засгийн газраас Дим Сам бондын төлбөрийг 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хийснээр ойрын хугацаанд Засгийн газраас төлөгдөх томоохон өр төлбөргүй болсон, “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 оны 2 дугаар хагаст 310.0 сая ам.долларын

санхүүжилт орохоор хүлээгдэж байгаагаас үзэхэд 2018 оны 2 дугаар хагаст төлбөрийн тэнцлийн ашиг нэмэгдэхээр хүлээгдэж байна. Иймд валютын ханшид түр зуурын шинжтэй өсөлт гарч болох ч, төгрөгийн ханшид гарсан богино хугацааны хэлбэлзэл удаан үргэлжлэхгүй, ханшийн хэлбэлзэл бага байх төлөвтэй байна.

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг эдийн засгийн суурь хүчин зүйлстэй нийцтэй, уян хатан тогтоох зарчмыг баримталдаг бөгөөд зах зээлд түр зуурын шинжтэй огцом хэлбэлзэл үүссэн үед хэлбэлзлийг бууруулах зорилгоор зах зээлд оролцдог. Иймд бид цаашид зах зээлд түр зуурын шинжтэй, огцом хэлбэлзэл үүссэн тохиолдолд богино хугацааны эрэлт, нийлүүлэлтийн зөрүүг нөхөх зорилгоор зах зээлд оролцох чиглэлийг баримтлан ажиллаж байна.

**Асуулт 5: Ам.долларын нийлүүлэлт буюу орох урсгалыг нэмэгдүүлэх тал дээр авч хэрэгжүүлж буй тодорхой арга хэмжээ?**

Засгийн газар, Олон Улсын Валютын Сангийн хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд 2018 онд нийт 130.1 сая ам.долларын санхүүжилт орсон бөгөөд 6 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар хөтөлбөрийн 4 дэх шатны үнэлгээ хийгдэж, ОУВС-гийн захирлуудын зөвлөлийн хурлаас Монгол Улсад 36.91 сая ам.долларын санхүүжилт олгохоор болсон.

Мөн гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх, улмаар зах зээлд оролцогчдын итгэлийг бэхжүүлэх зорилгоор “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг зохион байгуулснаар 2018 оны эхний 5 сарын байдлаар иргэд, аж ахуйн нэгжээс худалдан авсан алтны хэмжээ 7134.1 килограммд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 6.4 хувь буюу 429.3 килограммаар нэмэгдсэн байна.